



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 14 сарын 21 өдөр

Дугаар 34

Мандалговь

Г О.Мөнхзулыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны 5 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Отгонпүрэвийн Мөнхзул 50.3 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа О.Мөнхзулын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн Дундговь аймаг дахь
салбар зөвлөлийн 2022 оны 7 дугаар сарын
24-ны өдрийн 10 дугаар тогтоолын хавсралт



**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтний
албан тушаалд нэр дэвшүүлсэн О.Мөнхзулын тухай
дүгнэлт**

1. О.Мөнхзул нь 1985 онд Дундговь аймгийн Сайнцагаан суманд төрсөн. 37 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2003-2009 онд ШУТИС-ийг сантехникийн инженер мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. 2010-2011 онд МСҮТ-д сантехникийн цагийн багш, 2011-2012 онд Сайнцагаан сумын Хот тохижуулах газарт инженер, 2012 онд 5 сарын хугацаанд Газрын харилцаа барилга хот байгуулалтын газарт барилгын хяналтын инженер, 2012 оны 8 сараас аймгийн ЗДТГ-т барилга хот байгуулалт, дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байна.
4. О.Мөнхзулын төрийн албанд ажилласан дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ